

Сургуулийн ОДОД

Хятадын Хүүхэд залуучуудын наадам Бээжинд болж өнгөрлөө уран сайхны

Уг арга хэмжээг анх 2008 оны 1-р сарын 29-ны өдөр "Баясгалант Олимпын Аялал" уриан доор Бээжинд эхлүүлснээр Соёлын Яам, Боловсролын Яам, Бээжингийн Олимпын Зохион Байгуулах Хороо, Хятадын Төв Телевиз CCTV зэргийн өндөр үнэлгээ болон зоригжуулал дэмжлэгийг хүртэж, уг арга хэмжээг БОЗБХ-ныхон Бээжингийн Олимпын соёлын арга хэмжээний нэгэн агуулгаар 6-р хугацааны Олимпиакийн соёлын арга хэмжээнд нэгтгэн оруулсан байгаа. Томоохон хэмжээний энэ арга хэмжээг CCTV-гийнхэн өргөнөөр ухуулан, олон талаар мэдээлж байснаас гадна Бээжин хотын телевиз, Ринь минь ри бао сонин зэрэг олон хэвлэлийнхэн арга хэмжээний агуулгыг дэлгэрэнгүй мэдээлж байсан юм. Хятадын 20 гаруй муж, өөртөө засах район, хотуудаас сонгогдон шалгарсан 1000 өсвөр насны уран сайханчид өнгөрсөн жил Бээжинд болсон анх дахь наадамд оролцожээ.

1

Дуу хөгжим



Хятадын Хүүхэд залуучуудын уран сайхны наадам бол Хятадын Соёлын Яам-ны дэргэдэх Хятадын нийгэм, соёлын хөгжлийн сан болон Өсвөр насны нэг үеийнхний ажил хариуцсан комиссын хамтран эрхэлсэн Хятадын хэмжээний хүүхдүүд, залуучуудын ур авьяасаа гаргах, харилцаа солилцооны томоохон арга хэмжээ юм. Уг арга хэмжээг анх 2008 оны 1-р сарын 29-ны өдөр "Баясгалант Олимпын Аялал" уриан доор Бээжинд эхлүүлснээр Соёлын Яам, Боловсролын Яам, Бээжингийн Олимпын Зохион Байгуулах

Хороо, Хятадын Төв Телевиз ССТV зэргийн өндөр үнэлгээ болон зоригжуулал дэмжлэгийг хүртэж, уг арга хэмжээг БОЗБХ-ныхон Бээжингийн Олимпын соёлын арга хэмжээний нэгэн агуулгаар 6-р хугацааны Олимпикийн соёлын арга хэмжээнд нэгтгэн оруулсан байгаа. Томоохон хэмжээний энэ арга хэмжээг ССТV-гийнхэн өргөнөөр ухуулан, олон талаар мэдээлж байснаас гадна Бээжин хотын телевиз, Ринь минь ри бао сонин зэрэг олон хэвлэлийнхэн арга хэмжээний агуулгыг дэлгэрэнгүй мэдээлж байсан юм. Хятадын 20 гаруй муж, өөртөө засах район, хотуудаас сонгогдон шалгарсан 1000 өсвөр насны уран сайханчид өнгөрсөн жил Бээжинд болсон анх дахь наадамд оролцожээ.



Манай радиогийн мэрэгжилтэн Чулуунцэцэг "Морин хуур" хамтлагыг сурвалжилж байна

Өргөн олон хүүхэд залуучууд, уран сайханчдын хэрэгцээ шаардлагад зохицуулахын үүднээс уг наадмыг зохиож байгаа холбогдох талынхан Хятадын хүүхэд залуучуудын уран сайхны 2-р наадмыг 2008 оны 10-р сарын 8-ны өдрөөс 2009 оны 2-р сар хүртэл зохион явуулж, энэ удаагийн наадмын уриаг "Сургуулийн одод" гэж нэрлэсэн байна. "хүүхдийн



уран сайхныг үзүүлэлт", "сургуулийн хүрээний соёл үзүүлэлт", "уран сайхны боловсролын үр бүтээл" зэрэг агуулгаар гол болгож, хүүхдийн ур авьяасыг нь хүмүүжүүлэх, хүүхдүүдэд гэгээн саруул итгэл хүслэн хайрлах, хүүхэд залчуудын уран сайхны боловсролын шилдэг боловсон хүчнийг хүмүүжүүлэхээр гол зорилгоо болгожээ. 2-р сарын эхээр энэ удаагийн наадмын эцсийн шалгаруулалтаар дамжиж, Хятадын олон муж районоос хүрэлцэн ирэн, олон үндэстний 500 гаруй хүүхэд залуучууд Бээжинд цугларч ур авьяасаа гаргацгааж билээ.



Наадмыг 5-9 насны хүүхдийн баг, 10-12 насны хүүхдийн баг, анх дундын сурагчдын баг, өндөр дундын сурагчдын баг ба их сургуулийн оюутнуудын баг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн баг гэж 6 хэсэгт хувааж зохион байгуулжээ.

Сайт ашиглагчдын хувьд сонирхуулахад, Бээжинд болсон "Сургуулийн одод" нэрэмжит Хятадын Хүүхэд залуучуудын уран сайхны 2-р наадамд Өвөр Монголын Өөртөө Засах Район, Шинжян зэрэг олон нутгаас хүрэлцэн ирэн монгол үндэстний хүүхэд залуучууд нар бас наадамд гарамгай оролцож, үндэстний дуу хуураа эгшиглүүлж, дуулж билээ.

Үүний дотор алс холын Шинжян районы Баянгол нутгаас хүрэлцэн ирсэн "Ойрад монгол- хүүхдийн морин хуурын хамтлаг"-ийнхан наадамдаа амжилттай оролцож, хүүхдийн багийнхаа дотор түрүүлж, нэгдүгээр зэргийн шагнал олсон байна.

Басан, Аянга, Нам-бат зэрэг хамгийн бага нь 9 настай, ахлаач нь 14 настай нийт 9 хүүхэд, морин хуураа арай ядан дааж чирч атлаа, ээрэм талын дээгүүр, адуу мал янцгааж байгаа ч юм шиг, хонь хурга майлж байгаа ч юм шиг хөөрхөн мөртөө дэвжээнтэй аялгууг хуурын хоёр утсаараа эгшиглүүлж чадаж байгаа нь бахархалтай санагдаж байлаа. Ингээд энэ бяцхан морин хуурын хамтлагийнхан ар нутгаа зорихоос өмнөхөн манай радиод зочлож билээ.





Морин хуур ер нь нийт монголын ганц хөгжим гэлтэй гэдэг боловч баруун зүгийн монголчуудын хувьд товшуур хөгжим илүү дэлгэрч ирсэн түүхтэй. Гэсэн ч сүүлийн үед Хятадын олон газрын монголчуудын харилцаа солилцоо өргөжиж, хүүхэд залуучууд бие биенээсээ сурах юм их болсон билээ.



Энэ утгаараа Шинжяний олон газрын хүүхэд залуучууд морин хуурыг бас эвлүүлэн дарчих нь бас цөөнгүй харагдах болжээ. Энэ удаагийн наадамд оролцсон "Ойрад монгол- хүүхдийн морин хуурын хамтлаг"-гийн хүүхэд морин хуур сурч эхлээд арай жил болоогүй байгаа гэж энэ хамтлагийг дагуулсан багш нь Чи Линь гэдэг нэртэй



Өвөр монголын жирим нутагтай залуу хэлж байлаа. Энэ залуу Хөх-хотод урлагийн сургууль төгсөөд Шинжянд очиж ажиллаж байгаа гэнэ. Тэгээд өөрийн дур бахаасаа тухайн нутгийн хүүхэд залуучуудад морин хуур зааж дасгаж, одоо тэрээр Шинжянд 400 гаруй морин хуурын шавьтай болсон гэж хэлж байлаа.

